



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 1/12

Улаанбаатар хот

「 Улсын аварга шалгаруулах Дартсын 2026
оны сонирхогчдын тэмцээнд баг
тамирчдыг оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын аварга шалгаруулах Дартсын 2026 оны сонирхогчдын тэмцээн 2026 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдах тул тэмцээнд дүүргийн дартсын “Оч” клубын тамирчдыг бэлтгэн оролцуулахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

2. Тэмцээнд оролцоход шаардлагатай төсвийг хавсралтаар баталж 1,960,000 (Нэг сая есөн зуун жаран мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т, санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил\захирамж

1226010034

Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 07 сарын 22-ны өдрийн
01/22 дугаар захирамжийн хавсралт

ДАРТСЫН 2026 ОНЫ СОНИРХОГЧДЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНД "ОЧ" КЛУБЫН БАГ ТАМИРЧИД ОРОЛЦОХОД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бүртгэлийн хураамж	Багийн төрөл	2	150,000	300,000
2		Ганцаарчилсан төрөл	10	70,000	700,000
3		Холимог хосын төрөл	3	120,000	360,000
4		Дан хосын төрөл	5	120,000	600,000
Нийт					1,960,000